



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/501

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун бүсийн даншиг наадам, Аймгийн “Шигшмэл хурд” хурдан морьдын уралдаан зохион байгуулахад “Алтайн унага уяачдын холбоо”-д дэмжлэг болгож 3000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 3000.000 төгрөг /Гурван сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.17 тусгагдсан Спортын аварга хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 05-ны өдрийн
А/501 дүгээр захирамжийн хавсралт



БАРУУН БҮСИЙН ДАНШИГ НААДАМ, АЙМГИЙН “ШИГШМЭЛ ХУРД”
ХУРДАН МОРЬДЫН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ШАТАХУУНЫ ЗАРДАЛ,
АЙМГИЙН УЯАЧИД, МОРЬ УНААЧ ХҮҮХДЭД БЭЛЭГ ГАРДУУЛАХАД

№	Бараа материалын нэрс	Хэмжих нэгж	тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ /мян.төг/
1	Шатахууны үнэ	л	717	2090	1500000
2	Уяач, морь унаач хүүхдэд шагнал	ш	16	93750	1500000
Дүн					3000000

-оОо-